

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/188/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Т.НЯМ-ОЧИР
ТАНАА

2025.02.14 № 07/567
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 1,609,142.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж бүртгэлд тусгасан;
- Тус байгууллага худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 1,250,618.0 мянган төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авсан;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс төсөл, арга хэмжээтэй холбоотой 136,004.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн;
- Он дамжин хэрэгжих гэрээ байгуулж, 120,358.0 мянган төгрөгийг зарцуулсан.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол шуудан ХК нь БЕГ/20240101017 дугаартай "Сурах бичиг тээвэрлэн хүргэх" нээлттэй тендерт шалгарч, 990,000.0 мянган төгрөгийн төсөвтэй гэрээ байгуулан, ерөнхий боловсролын 791 сургуульд нийт 1,753.8 мянган ширхэг сурах бичгийг амжилттай түгээсэн. Үүний үр дүнд 2024-2025 оны хичээлийн жилийн эхэнд сурагчид шинээр хэвлэгдсэн сурах бичгээ хугацаанд нь хүлээн авсан бөгөөд энэ нь сүүлийн 20 жилийн хугацаанд сурах бичгийг хугацаанд нь түгээсэн анхны тохиолдол болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

"Ерөнхий боловсролын сургуульд 'Google for Education' программ хангамж, цахим хэрэглэгдэхүүнийг нэвтрүүлэхэд шаардлагатай лиценз, үйлчилгээг худалдан авах" ажлын хүрээнд 2024 оны 2 дугаар сарын 27-ны өдөр 18 дугаар бүхий гэрээ байгуулж, iCORE E&C ХХК-тай хамтран хэрэгжүүлсэн байна. Энэ хөтөлбөр, арга хэмжээг 4,344,600.0 мянган төгрөгөөр санхүүжүүлжээ.

Мөн "Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай" хуулийн хүрээнд тайлант онд боловсролын салбарын 7839 /давхардсан тоогоор/ алдар цолтон ахмад настанд нийт 1,199,300.0 мянган төгрөгийг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг газрын жилийн үйл ажиллагааны тайланд дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

- "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 100 хувьтай, 14 арга хэмжээний биелэлт бүрэн хангагдсан;
- "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 8 арга хэмжээний хэрэгжилт 98.7 хувьтай, үүнээс 7 нь 100 хувь биелж, 1 нь тодорхой үр дүнд хүрсэн;
- "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 28 арга хэмжээний хэрэгжилтийн түвшин 96.8 хувьтай гарсан бөгөөд 23 нь бүрэн хэрэгжиж, 4 нь 80-95 хувийн хэрэгжилттэй, 1 нь 50 хувьтай буюу эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэлэгджээ. Тайлангийн мэдээлэл <https://meds.igovernment.mn/home/> системээр тайлагнасан;
- "Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний 10 заалтын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тайлагнаж, 8 заалтын биелэлтийг үнэлсэн бөгөөд 2 заалтыг хяналтаас гаргах саналыг гаргасан байна. Тайлагнасан заалтуудаас 3 нь бүрэн хэрэгжиж, 3 нь тодорхой үр дүнд хүрсэн, 2 нь эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэгдсэн бөгөөд нийт хэрэгжилтийн биелэлт 82.8 хувьд хүрсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	252,329,492.16	154,205,714.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,851.00	5,851.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	5,851.00	5,851.00
31210	Төгрөг	5,851.00	5,851.00
31213	Арилжааны банк дахь харилцах	5,851.00	5,851.00
33	АВЛАГА	232,668,942.66	136,004,487.35
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	101,118.98	12,791,375.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	232,567,823.68	123,213,111.75
35	БАРАА МАТЕРИАЛ	19,654,698.50	18,195,376.00
35400	Хангамжийн материал	19,654,698.50	18,195,376.00
35410	Бичиг хэргийн материал	14,139,698.50	17,067,876.00
35420	Аж ахуйн материал	5,330,000.00	346,500.00
35470	Бусад хангамжийн материал	185,000.00	781,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,782,111,188.05	6,570,890,765.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,782,111,188.05	6,570,890,765.26
39200	Биет хөрөнгө	6,526,558,513.05	6,390,641,320.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,195,347,418.00	6,195,347,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(476,565,186.00)	(571,878,223.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	109,101,653.00	32,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(109,101,653.00)	(2,666,666.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,516,315,098.55	1,419,379,962.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(915,499,532.34)	(884,970,916.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	495,961,276.02	343,327,131.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(289,198,551.18)	(140,095,375.86)
39217	Ном	197,990.00	197,990.00
39300	Биет бус хөрөнгө	255,552,675.00	180,249,445.00
39301	Программ хангамж	345,047,716.00	310,499,320.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(89,495,041.00)	(130,249,875.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,034,440,680.21	6,725,096,479.61
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,300,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,300,000.00	-
41300	Өглөг	5,300,000.00	-
41360	Бусад өглөг	5,300,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	5,300,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,029,140,680.21	6,725,096,479.61
51	Засгийн газрын хувь оролцоо	7,029,140,680.21	6,725,096,479.61
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,767,278,705.68	6,767,278,705.68
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,767,278,705.68	6,767,278,705.68
51200	Хуримтлагдсан үр дүн	(703,105,040.97)	(1,007,149,241.57)
51210	Өмнөх үеийн үр дүн	(10,392,221.58)	(703,105,040.97)
51220	Тайлант үеийн үр дүн	(692,712,819.39)	(304,044,200.60)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	964,967,015.50	964,967,015.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,034,440,680.21	6,725,096,479.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,453,529,542.21	32,708,620,415.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,749,452,000.00	3,816,160,109.35
120	Нийтлэг татварын бус орлого	3,749,452,000.00	3,816,160,109.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,697,997,350.00	3,477,905,757.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,690,000,000.00	3,477,905,757.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,997,350.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	51,454,650.00	330,414,352.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	7,840,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,704,077,542.21	28,892,460,306.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,533,659,396.21	26,859,389,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,533,659,396.21	26,859,389,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,170,418,146.00	2,033,070,706.48
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,276,113,716.00	736,613,726.88
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	649,973,541.00	719,708,419.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,244,330,889.00	576,748,560.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26,146,242,361.60	33,012,664,616.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,146,242,361.60	33,012,664,616.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,364,279,044.49	30,583,914,190.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,657,523,960.65	4,957,563,742.87
210101	Үндсэн цалин	2,198,772,288.22	2,835,240,853.66
210102	Нэмэгдэл	793,391,448.68	995,457,956.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	464,422,179.82	594,265,416.16
210104	Урамшуулал	200,938,043.93	532,599,516.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	453,186,746.27	617,968,122.17
210201	Тэтгэврийн даатгал	321,448,965.47	445,942,222.17
210202	Тэтгэмжийн даатгал	32,990,412.06	43,006,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,370,329.42	21,503,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,544,276.48	21,503,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	65,832,762.84	86,013,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,782,330.57	181,970,378.22
210301	Гэрэл, цахилгаан	113,306,146.92	129,647,524.50
210302	Түлш, халаалт	37,725,039.88	41,879,685.96
210303	Цэвэр, бохир ус	14,751,143.77	10,443,167.76
2104	Хангамж, бараа материалын зардал	264,520,613.40	289,453,127.27

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210401	Бичиг хэрэг	168,780,645.50	196,956,242.44
210402	Тээвэр, шатахуун	65,765,268.00	61,406,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,818,398.90	19,614,527.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,156,301.00	11,475,507.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,902,500.00	20,137,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,815,000.00	2,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,448,000.00	17,637,900.00
210604	Урсгал засвар	639,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	662,049,814.00	377,058,200.00
210702	Дотоод албан томилолт	662,049,814.00	377,058,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,880,975,799.36	17,909,049,644.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,880,123,987.36	17,898,956,513.54
210803	Даатгалын үйлчилгээ	372,060.00	1,024,731.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,252.00	194,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	48,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264,000.00	8,874,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,264,337,280.24	6,230,713,075.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,046,283,641.00	5,018,062,672.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,666,496,106.21	645,056,228.77
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	551,557,533.03	567,594,174.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,781,963,317.11	2,428,750,425.80
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,638,713,616.00	1,613,030,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,313,150,000.00	1,429,950,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,648,616.00	157,080,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	219,915,000.00	26,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	143,249,701.11	815,720,425.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,896,200.47	815,720,425.80
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,353,500.64	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(692,712,819.39)	(304,044,200.60)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(692,712,819.39)	(304,044,200.60)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	26,881,236,530.42	32,591,143,887.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,691,180,000.00	3,466,115,757.35
120	Нийтлэг татварын бус орлого	3,691,180,000.00	3,466,115,757.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,691,180,000.00	3,466,115,757.35
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,690,000,000.00	3,466,115,757.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,180,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,190,056,530.42	29,125,028,130.16
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	18,533,659,396.21	26,859,389,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	18,533,659,396.21	26,859,389,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,656,397,134.21	2,265,638,530.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,276,113,716.00	752,579,808.83
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,135,952,529.21	782,525,100.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,244,330,889.00	730,533,620.73
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,429,978,114.42	32,565,184,487.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,429,978,114.42	32,565,184,487.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,416,796,973.63	30,013,220,949.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,646,842,651.32	4,942,054,100.84
210101	Үндсэн цалин	2,188,090,978.89	2,819,731,211.63
210102	Нэмэгдэл	793,391,448.68	995,457,956.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	464,422,179.82	594,265,416.16
210104	Урамшуулал	200,938,043.93	532,599,516.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	453,186,746.27	617,968,122.17
210201	Тэтгэврийн даатгал	321,448,965.47	445,942,222.17
210202	Тэтгэмжийн даатгал	32,990,412.06	43,006,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,370,329.42	21,503,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,544,276.48	21,503,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	65,832,762.84	86,013,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,782,330.57	181,970,378.22
210301	Гэрэл, цахилгаан	113,306,146.92	129,647,524.50
210302	Түлш, халаалт	37,725,039.88	41,879,685.96
210303	Цэвэр, бохир ус	14,751,143.77	10,443,167.76
2104	Хангамж, бараа материалын зардал	105,948,393.90	130,814,600.77
210401	Бичиг хэрэг	74,274,030.00	83,104,912.94
210402	Тээвэр, шатахуун	6,686,568.00	21,381,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,818,398.90	19,614,527.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,169,397.00	6,713,310.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,502,500.00	26,934,030.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,815,000.00	3,363,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,448,000.00	2,394,630.00

Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210604	Урсгал засвар	1,239,500.00	21,175,900.00
2107	Томилолт, зочны зардал	662,049,814.00	379,533,200.00
210702	Дотоод албан томилолт	662,049,814.00	379,533,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,571,758,969.36	18,051,550,228.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,564,442,157.36	18,041,457,097.19
210803	Даатгалын үйлчилгээ	372,060.00	1,024,731.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,252.00	194,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	48,500.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,729,000.00	8,874,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,794,725,568.21	5,682,396,289.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,010,230,748.00	5,014,510,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,784,494,820.21	667,886,289.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,013,181,140.79	2,551,963,537.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,637,363,616.00	1,613,030,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,311,800,000.00	1,429,950,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,648,616.00	157,080,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	219,915,000.00	26,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	375,817,524.79	938,933,537.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	124,896,200.47	815,720,425.80
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	250,921,324.32	123,213,111.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	451,258,416.00	25,959,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	451,258,416.00	25,959,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	451,258,416.00	25,959,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	451,258,416.00	25,959,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	451,258,416.00	25,959,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(451,258,416.00)	(25,959,400.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,851.00	5,851.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,851.00	5,851.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(10,392,221.58)	7,721,853,499.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(10,392,221.58)	7,721,853,499.60
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(692,712,819.39)	(692,712,819.39)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(703,105,040.97)	7,029,140,680.21
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(703,105,040.97)	7,029,140,680.21
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(304,044,200.60)	(304,044,200.60)
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(1,007,149,241.57)	6,725,096,479.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,371,939,800.00	29,509,784,931.55	1,862,154,868.45	94.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,371,939,800.00	29,509,784,931.55	1,862,154,868.45	94.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,473,762,300.00	27,896,754,931.55	1,577,007,368.45	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,372,759,600.00	4,372,707,516.30	52,083.70	100.0
210101	Үндсэн цалин	2,438,720,600.00	2,250,384,627.09	188,335,972.91	92.3
210102	Нэмэгдэл	974,479,800.00	995,457,956.15	(20,978,156.15)	102.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	405,957,400.00	594,265,416.16	(188,308,016.16)	146.4
210104	Урамшуулал	553,601,800.00	532,599,516.90	21,002,283.10	96.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	547,812,000.00	547,812,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	375,786,100.00	375,786,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	43,006,500.00	43,006,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,503,200.00	21,503,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	21,503,200.00	21,503,200.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	86,013,000.00	86,013,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,116,500.00	181,970,378.22	5,146,121.78	97.2
210301	Гэрэл, цахилгаан	135,950,400.00	129,647,524.50	6,302,875.50	95.4
210302	Түлш, халаалт	40,473,600.00	41,879,685.96	(1,406,085.96)	103.5
210303	Цэвэр, бохир ус	10,692,500.00	10,443,167.76	249,332.24	97.7
2104	Хангамж, бараа материалын зардал	93,968,500.00	92,177,587.83	1,790,912.17	98.1
210401	Бичиг хэрэг	43,287,600.00	44,467,900.00	(1,180,300.00)	102.7
210402	Тээвэр, шатахуун	21,396,300.00	21,381,850.00	14,450.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,570,600.00	19,614,527.83	2,956,072.17	86.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,714,000.00	6,713,310.00	690.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,945,100.00	52,893,430.00	51,670.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,327,700.00	29,322,900.00	4,800.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,401,500.00	2,394,630.00	6,870.00	99.7
210604	Урсгал засвар	21,215,900.00	21,175,900.00	40,000.00	99.8
2107	Томилолт, зочны зардал	28,583,200.00	28,395,000.00	188,200.00	99.3
210702	Дотоод албан томилолт	28,583,200.00	28,395,000.00	188,200.00	99.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,900,609,400.00	17,381,023,669.19	1,519,585,730.81	92.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,890,423,300.00	17,370,930,538.19	1,519,492,761.81	92.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,025,000.00	1,024,731.00	269.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	221,100.00	194,400.00	26,700.00	87.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	-	66,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,874,000.00	8,874,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,289,968,000.00	5,239,775,350.01	50,192,649.99	99.1

**Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,064,660,000.00	5,014,510,000.00	50,150,000.00	99.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	225,308,000.00	225,265,350.01	42,649.99	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,898,177,500.00	1,613,030,000.00	285,147,500.00	85.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,898,177,500.00	1,613,030,000.00	285,147,500.00	85.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,714,977,300.00	1,429,950,000.00	285,027,300.00	83.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	157,080,000.00	157,080,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,120,200.00	26,000,000.00	120,200.00	99.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,371,939,800.00	29,509,784,931.55	1,862,154,868.45	94.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,974,699,800.00	26,043,669,174.20	931,030,625.80	96.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	26,974,699,800.00	26,043,669,174.20	931,030,625.80	96.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,397,240,000.00	3,466,115,757.35	931,124,242.65	78.8
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,397,240,000.00	3,466,115,757.35	931,124,242.65	78.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,851.00	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,851.00	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	173	171	2	98.8
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	160	167	(7)	104.3
620003	Үйлчлэх ажилтан	9	0	9	0.0
620004	Гэрээт ажилтан	3	3	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,265,638,530.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,265,638,530.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,142,425,418.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		569,346,584.54
210101	Үндсэн цалин		569,346,584.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		70,156,122.17
210201	Тэтгэврийн даатгал		70,156,122.17
2104	Хангамж, бараа материалын зардал		38,637,012.94
210401	Бичиг хэрэг		38,637,012.94
2107	Томилолт, зочны зардал		351,138,200.00
210702	Дотоод албан томилолт		351,138,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		670,526,559.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		670,526,559.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		442,620,939.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		442,620,939.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		123,213,111.75
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		123,213,111.75
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		123,213,111.75
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,265,638,530.16
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,265,638,530.16
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		752,579,808.83
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		782,525,100.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		730,533,620.73

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 6,926,346.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 6,490,418.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 435,927.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/191 тушаалын хавсралтаар батлагдсан, нийт 1,609,142.4 мянган төгрөгийн төсөвтэй "Амьдралын мод" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Элф верс хөтөлбөр ХХК-тай 4 гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлийн баримт дутуу, гэрээг эцэслэн дүгнээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.	1	1,609,142.4			1	1,609,142.4				
2	Сураад ХХК-аар гүйцэтгүүлсэн 250,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Суралцахуйн цахим систем ашиглан суралцагчийн сурлагын хоцрогдол түвшинг тогтоох, бие даан суралцах үйлийг дэмжих, хоцрогдол арилгах, суралцагчийн гүйцэтгэлийн түвшинг ахиулах арга замыг туршин хөгжүүлэх" ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор боловсролын сургалтын 22 байгууллагатай гэрээ байгуулан дамжуулан зарцуулсан, мөн гэрээ байгуулах сургуулийг хэрхэн сонгосон нь тодорхойгүй, гэрээг дүгнэж, акт үйлдээгүй байна.		250,000.0				250,000.0				
3	Сургуулийн судалгаа хөгжлийн шинэ монгол төв НҮТББ-аар гүйцэтгүүлсэн 800,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй "Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг сайжруулах хөтөлбөр, арга хэмжээ" ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор боловсролын сургалтын 80 байгууллагаар дамжуулан зарцуулсан байна. Ажлын гүйцэтгэлийн анхан шатны баримт дутуу байна.	1	800,000.0			1	800,000.0				
4	"Сургалтын хэрэглэгдэхүүний жишиг жагсаалт"-ыг үндэслэн Mlab.02 цахим платформд сургалтын хэрэглэгдэхүүний нэгдсэн бүртгэлийг хийх 200,618.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг шууд гэрээ байгуулах зорилгоор 1 байгууллага, 12 иргэнтэй гэрээ байгуулан ажилласан байна. Ажлын гүйцэтгэлийн анхан шатны баримт дутуу байна.		200,618.0				200,618.0				

**Боловсролын ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

5	Математикийн хичээлд программ хангамж ашиглах сургалтыг турших зорилгоор Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны А/402 дугаар тушаалаар төсвийн жил дамнуулан Баянзүрх дүүргийн 3 сургуультай №386, 387, 388 дугаар бүхий гэрээ байгуулан 57,750.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан тэгш хамруулах боловсролын цахим платформ бий болгох зорилгоор Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны А/360 дугаар тушаалаар төсвийн жил дамнуулан Адина-Тэгш Боломж ТББ-тай №357 дугаар бүхий гэрээ байгуулан 62,608.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	120,358.0			1	120,358.0				
6	Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны А/413 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангид ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод бэлтгэх үйл ажиллагаа зохион байгуулах" ажлын 299,923.4 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлэхээс зайлсхийж, 2024 оны 12 дугаар сарын 27-нд боловсролын сургалтын 20 байгууллагад шилжүүлсэн байна.	1	299,923.4					1	299,923.4		
7	Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036)-ыг баталж, уг үзэл баримтлалын дагуу Боловсролын сайдын шийдвэрээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулах ажлыг эхлүүлсэн байна. Боловсролын ерөнхий газар нь хэрэгжээд дуусаж байгаа 2014 онд батлагдсан хуучин хөтөлбөрийн хүрээнд Ай И Ди Си ХХК-тай 2024.05.24-ний өдөр "Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх /Бага анги 1-5/ үйлчилгээг худалдан авах" №143 дугаар бүхий 3,510,300.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй гэрээ байгуулан санхүүжилтийг бүрэн олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	3,510,300.0			1	3,510,300.0				
8	Тайлант хугацаанд төсөл, арга хэмжээтэй холбоотой 136,004.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.	1	136,004.5					1	136,004.5		
Дүн		6	6,926,346.3	0	-	4	6,490,418.4	2	435,927.9	0	